



105  
Xaneg p

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН  
ҮНДЭСНИЙ ПАРКЫН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2014 оны 2 сарын 28 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

Г

Г

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, "Мэдээллийн технологийн үндэсний паркын дүрэм"-ийн 8 дугаар зүйлийн 8.5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. "Хаяг, реклам байршуулах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Энэхүү тушаал батлагдан гарсантай холбогдуулж Мэдээллийн технологийн үндэсний парк болон түрээслэгч байгууллагын хэмжээнд бүрэн танилцуулж, цаашид дагаж мөрдөх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар /Ц.Эрдэнэлхам/-т даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Д-р Ц.ТҮВШИНТӨР





106

## ХАЯГ, РЕКЛАМ БАЙРШУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Мэдээлийн технологийн үндэсний парк /цаашид "МТҮП" гэх/-ын байрны гадна болон дотор хэсэгт зар сурталчилгаа, байгууллагын хаяг, лого /цаашид хамтад нь "Зар сурталчилгааны байгууламж" гэх/ байршуулахтай холбогдуулан МТҮП болон аж ахуй нэгж, иргэнтэй үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2 МТҮП-д Зар сурталчилгааны байгууламж байршуулснаар Паркын байрны өнгө үзэмж, зориулалт алдагдах, тухайн байгууламжыг буулгах болон албадан буулгасны дараа үүсэх аливаа санхүүгийн эрсдэл, буулгаснаас үүдэн тухайн байгууламж байршиж байсан газар нь материалын болон бусад байдлаар чанар нь алдагдах зэрэг серөг үр дагавар илэрдэг тул Зар сурталчилгааны байгууламж байршуулж буй аж ахуй нэгж, иргэнээс мөнгөн хуримтлал үсгэн дээрх хохирлыг барагдуулах үйл ажиллагаанд зориулан энэхүү журмыг боловсруулсан болно.

### Хоёр. Ерөнхий зүйл

- 2.1 МТҮП нь зар сурталчилгааны байгууламж байршуулах зөвшөөрөл олгохдоо компани, иргэний бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн энэхүү журамд нийцүүлэн олгоно.
- 2.2 МТҮП нь гадна зар сурталчилгааны байгууламж байршуулах аж ахуй нэгж, иргэдтэй ашиглалтын гэрээг 1 жил хүртэлх хугацаагаар байгуулна.
- 2.3 Ерөнхий захирал нь зар сурталчилгааны байгууламжийг байрлуулах талбайн зэрэглэл болон стандарт хэмжээг тогтооно. Тухайн зэрэглэл болон байгууламжийн хэлбэр, хэмжээ, төрлөөс хамаарч сар тутмын төлбөрийг зохицуулна.
- 2.4 МТҮП нь хийц, хэмжээ, өнгө үзэмж, аюулгүй байдалд дүгнэлт гаргаж, шинээр байрлуулж буй байгууламжыг хүлээн авна.

### Гурав. Зөвшөөрөл олгох, гэрээ сунгах, цуцлах болон төлбөр тооцоо

- 3.1 Байгууллага, аж ахуй нэгж иргэд нь МТҮП-ын байрны гадна болон дотор талд зар сурталчилгааны байгууламж байрлуулах хүсэлтээ МТҮП-д албан бичгээр гаргах бөгөөд гадна талд зар сурталчилгааны байгууламж байршуулах хүсэлтэндээ дараах материалыг хавсаргана. Үүнд :
  - 3.1.1 Байрлуулах болсон шалтгаан /хүсэлт/;
  - 3.1.2 Байгууламжын төрөл, тоо хэмжээ, эскиз /загвар/ зураг;
  - 3.1.3 Байрлуулах газрын фото монтаж;
  - 3.1.4 Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар /иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар/;
- 3.2 Зар сурталчилгааны байгууламж байршуулах талаар ирүүлсэн хүсэлтийг үндэслэн МТҮП нь ажлын 10 хоногт шийдвэрлэнэ.
- 3.3 Зар сурталчилгааны байгууламж байршуулахад тухайн байгууламжын онцлогоос /паркын стандартад нийцсэн/ хамаарч гэрээ байгуулалгүй /төлбөргүй/ зөвшөөрлийн үндсэн дээр байрлуулж болно.

- 3.4 Гадна байгууламжийг шинээр байрлуулснаас хойш ажлын 5 хоногийн дотор МТҮП нь тухайн байгууламжын хэлбэр, хийц, өнгө үзэмж нь албан хүсэлт болон гэрээнд заагдсаны дагуу хийгдсэн эсэх болон бусад холбогдох дүрэм журам, стандартад нийцэж буй эсэхийг нягтлан шалгасны үндсэн дээр ашиглалтад хүлээн авна.
- 3.5 Аж ахуй нэгж, иргэн нь холбогдох төлбөр тооцоо/барьцаа төлбөрөөс бусад/-г ашиглалтын гэрээ байгуулагдсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор МТҮП-ын холбогдох дансанд төвлөрүүлнэ.
- 3.6 Зар сурталчилгааны байгууламж байршуулах төлбөр тооцоо нь урьдчилсан төлбөрт байх бөгөөд МТҮП нь ашиглаагүй үлдсэн хугацаанд ямар нэг төлбөр/барьцаа төлбөрөөс бусад/-ийг буцаан олгохгүй.

#### Гэрээ сунгах

- 3.7 Аж ахуй нэгж, иргэн нь гэрээг сунгах хүсэлтээ гэрээний хугацаа дуусахаас 10 хоногийн өмнө хүргүүлсэн байна.
- 3.8 Гэрээг сунгах эсэх шийдвэрийг байгууламжийн ашиглалтын байдал, энэхүү журам болон гэрээний биелэлтийг үндэслэн МТҮП шийвдэрлэнэ.

#### Гэрээ цуцлах

- 3.9 Гэрээ байгуулах, сунгаснаас хойш ажлын 5 хоногийн дотор төлбөрийг төлөөгүй тохиолдолд гэрээ болон зөвшөөрлийг цуцлана.
- 3.10 Энэхүү журмын 3.4-т заасны дагуу шаардлага хангагүй бол гэрээг цуцлана.
- 3.11 Энэхүү журмын 4.11 дэх заалтыг зөрчсөн бол гэрээг цуцлана.
- 3.12 Энэхүү журам, ашиглалтын гэрээ болон холбогдох хууль, дүрэм журам, стандартыг ноцтой зөрчсөн болон аливаа гаргасан зөрчлөө арилгах талаар сануулсаар байтал тухайн зөрчлөө арилгалгүй 5 хоносон тохиолдолд гэрээг цуцлана.
- 3.13 Гэрээ цуцлагдсан, байгууламжыг зөвшөөрөлгүй, гэрээ байгуулалгүй байршуулсанаас хойш ажлын 3 хоногт багтаан байгууламжаа буулгаагүй тохиолдолд МТҮП нь тухайн байгууламжийг албадан буулгахад гарсан холбогдох төлбөр тооцоог тухайн аж ахуй нэгжээр нөхөн төлүүлнэ.
- 3.14 Албадан буулгаснаас үүсэх аливаа үр дагаварыг МТҮП нь хариуцахгүй.

#### Дөрөв. Байгууллага, аж ахуй нэгжийн эрх, үүрэг

##### Аж ахуй нэгж, иргэн нь дараах эрхтэй.

- 4.1 Зар сурталчилгааны байгууламж дээрээ өөрийн зар сурталчилгааг байрлуулах.
- 4.2 Зар сурталчилгааны төрөлд шинэлэг технологи ашигласан, зар сурталчилгааны байгууламжын шинэ төрлүүд нэвтрүүлсэн аж ахуй нэгж, байгууллага эхний жилийн нийт төлбөрөөс 10%-50% чөлөөлөгдөх хүсэлтээ МТҮП-д тавьж шийдвэрлүүлэх.
- 4.3 Тухайн байгууллагад талбай түрээслэж буй этгээд нь өөрийн байгууллагын албан ёсны хаяг логог үнэ төлбөргүй байршуулах тухай хүсэлт гаргах /Хаяг лого нь хэлбэр, хэмжээ, хийцийн хувьд албан ёсны, МТҮП хүлээн зөвшөөрсөн буюу тухайн байгууллагад байршиж буй албан ёсны хаяг логотой хэмжээний хувьд илүүгүй адил стандартынх байх/;

##### Аж ахуй нэгж, иргэн нь дараах үүрэгтэй.

- 4.4 Зар сурталчилгааны байгууламжаа ашиглалтад оруулах, ашиглах, техникийн болон аюулгүй ажиллагааны журмыг зөрчсөнөөс бусдад учруулсан хохирлыг бүрэн хариуцах.
- 4.5 Зар сурталчилгааны байгууламжийн бүрэн бүтэн, өнгө үзэмж, аюулгүй байдлыг хариуцах; урсгал засвар арчилгааг байнга хийж гүйцэтгэх.

- 4.6 Зар сурталчилгааны байгууламжаа буулгасны дараа тухайн байгууламж байршиж байсан газрыг анхны хэлбэрт нь оруулан засан сайжруулж хүлээлгэн өгөх. Хэрэв анхны хэлбэрт нь оруулан засан сайжруулж өгөөгүй тохиолдолд тухайн засан сайжруулалттай холбогдон гарах бүх төлбөр тооцоог МТҮП -д төлж барагдуулах үүрэгтэй.
- 4.7 Барьцаа төлбөрөөс бусад холбогдох төлбөр тооцоог гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 5 хоногийн дотор төлж барагдуулах.
- 4.8 Зар сурталчилгааны байгууламжийн төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлөх.
- 4.9 Зар сурталчилгааны хуулийг зөрчсөн зар сурталчилгаа байршуулснаас гарах хариуцлагыг бүрэн хариуцах.
- 4.10 Дараах тохиолдолд зар сурталчилгааны байгууламжаа өөрийн зардлаар буулгаж орчны тохижилт, засварыг хийж гүйцэтгэнэ.
- 4.10.1 Ашиглалтын гэрээний хугацаа дуусгавар болох, цуцлах;
  - 4.10.2 Зөвшөөрлийг хүчингүй болгох тохиолдолд.
- 4.11 Зар сурталчилгааны байгууламжийн талаар дараах үйл ажиллагааг хориглох бөгөөд ноцтой зөрчиild тооцно. Үүнд :
- 4.11.1 Зөвшөөрөлгүйгээр зар сурталчилгааны байгууламж байрлуулах;
  - 4.11.2 Гэрээ байгуулаагүй байж гадна зар сурталчилгааны байгууламж байршуулах ажлыг эхлүүлэх;
  - 4.11.3 Тухайн байрны бүрэн бүтэн байдал, утгат чанарыг алдагдуулсан зар сурталчилгааны байгууламж байршуулах;
  - 4.11.4 Зар сурталчилгааны байгууламж байрлуулах зөвшөөрлийг бусдад шилжүүлэх.

#### Тав. Хүлээлгэх хариуцлага

- 5.1 Энэхүү журмыг зөрчсөн гэм буруутай байгууллага, албан тушаалтан, иргэнд Зар сурталчилгааны тухай хууль, Барилгын тухай хууль болон бусад холбогдох дүрэм журмын хүрээнд хариуцлага оногдуулна.
- 5.2 Зар сурталчилгааны байгууламжийн ашиглалт, тэдгээрийн техник аюулгүй ажиллагааны шаардлага хангаагүй, төлбөрөө төлөөгүй болон зөвшөөрөлгүй зар сурталчилгааны байгууламж байрлуулсан байгууллага, иргэний зар сурталчилгааны байгууламжийг албадан буулгаж, гарсан зардлыг нөхөн төлүүлнэ.
- 5.3 Зар сурталчилгааны байгууламж байрлуулах, ашиглалтын явцад энэхүү журам, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам зөрчсөний улмаас бусдад учруулсан хохирлыг тухайн зар сурталчилгааны байгууламж эзэмшигч бүрэн хариуцна.



## ХАЯГ, РЕКЛАМ БАЙРШУУЛАХ БАЙГУУЛАМЖИЙН ЗЭРЭГЛЭЛ

- 1.1 Аж ахуй нэгж, иргэн нь гэрээний хугацаа дуусгавар болж гэрээ цүцлагдсаны дараа төлбөрийн болон энэхүү журам, гэрээний үүргийн зөрчилгүй бол байршуулсан барьцаа төлбөрөө буцаан авах эрхтэй.
- 1.2 Аж ахуй нэгж, иргэн нь өөрийн түрээслэж буй талбайн дотор талд зар сурталчилгаа, хаяг реклам байршуулхад төлбөргүй болно.
- 1.3 Байгууламж байршуулсаны төлбөр нь урьдчилсан төлбөрт байх бөгөөд МТҮП нь аж ахуй нэгжийн барьцаа төлбөрөөс бусад төлсөн төлбөрийг ямарч тохиолдолд буцаан олгохгүй.
- 1.4 Аж ахуй нэгж, иргэн нь доорх зэрэглэлийн дагуу сарын суурь төлбөрийг төлж барагдуулна. Үүнд:

№	БАЙРШУУЛАХ ТАЛБАЙН НЭР	ЗЭРЭГЛЭЛ	САРЫН СУУРЬ ТӨЛБӨР	БАРЬЦАА ТӨЛБӨР
1	Паркын төв хаалганы хэсэг	1	200,000.00₮	400,000.00₮
2	Паркын төв замруу харсан дээвэр хэсэг	1	200,000.00₮	400,000.00₮
3	Паркын байрны төв замруу харсан хэсгийн зүүн болон баруун тал /Байрны төв зам руу харсан нүүрэн талын боломжит талбай/	1	200,000.00₮	400,000.00₮
4	Паркын байрны төв замын эсрэг харсан дээвэр болон бусад хэсэг	2	150,000.00₮	300,000.00₮
5	Паркын 1 давхарын хэсэг /байрны дотор тал/	2	150,000.00₮	300,000.00₮
6	Паркын үүдэн хэсэг /байрны дотор тал/	2	150,000.00₮	300,000.00₮
7	Паркын 2 давхар/байрны дотор тал/	3	80,000.00₮	160,000.00₮
8	Паркын 3 давхар/байрны дотор тал/	3	80,000.00₮	160,000.00₮
9	Паркын 4 давхар/байрны дотор тал/	3	80,000.00₮	160,000.00₮
Нэмэгдэл төлбөр /Сар бүрийн суурь төлбөр дээр нэмэгдэнэ. /	1. "Олон тооны /1ш дээш/" – Ширхэг бүр нь сарын суурь төлбөрийн 30 хувиас багагүй байна. 2. "Лед гэрлэн" - Сарын суурь төлбөрийн 40 хувиас багагүй байна. 3. "Суурь төлбөртэй /нэмэлт төлбөргүй/ байршиж буй бусад байгууламжаас давсан хэмжээтэй" - Сарын суурь төлбөрийн 50 хувиас багагүй байна. 4. "Дүрс бичлэг, текст гаргах зориулалттай дэлгэцэн байгууламж бүхий" – Сарын суурь төлбөрийн 80 хувиас багагүй байна.			

\* Энэхүү төлбөр нь 2014 оны эхний улирлын зах зээл, эдийн засгийн судалгаан дээр үндэслэгдэн тогтоогдсон болно.

\* Талууд нэмэлт төлбөр дээр харилцан тохиролцож чадахгүй бол МТҮП нь тухайн байгууламжыг байрлуулхаас татгалзах, албадан буулгах эрхтэй.

\* Тухайн байгууламжын үнэгүй байрших хаягны стандарт хэмжээ нь 40x60см –аас илүүгүй хэмжээнийх байна.